Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А / 95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Хүний эрхийн бодлогын газар
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хүний эрхийн бодлогын газрын дарга	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж, 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Хүний эрх, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах, нэгж прокурорын газрыг мэргэжлийн удирдлагаар хангах.

Албан тушаалын зорилт:

1.Хүний эрх, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;
2.Гэмт хэрэг, зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;
3.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулах;
4.Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх, газар, хэлтсийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Хүний эрх, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг үнэлж дүгнэх.	Бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлж, ажлын чанар, үр нөлөөг сайжруулах арга хэмжээ авсан байна.	Г, Х
	1.2.Хүний эрх, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл солилцох, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.	Хамтран ажиллаж, мэдээлэл солилцсон байна.	Г, Ш
	1.3.Зөрчил шалган шийдвэрлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, шийдвэр гүйцэтгэх байгууллагын тушаал, шийдвэр хүний эрхийг зөрчих, эрүү шүүлт тулгах нөхцөлийг бий болгож болзошгүй гэж үзвэл хүчингүй болгуулах санал танилцуулах.	Эрх зүйн баримт бичиг, шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авсан байна.	Г, Х
	Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр		
	1.4.Хүний эрхийн чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө, зөвлөмжийн хүрээнд авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг нэгтгэн зохион байгуулах, биелэлтийг тооцох, тайлагнах.	Биелэлтийг тооцож, тайлагнасан байна.	Х, Ш
	1.5.Хүний эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн зөвлөмж, мэдээлэл, шаардлагын биелэлтийг хангуулах, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх.	Хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн байна.	Х, Ш
	1.6.Хүний эрхийн олон улсын стандарт, гадаад улсын эрх зүйн орчныг судалж, санал, дүгнэлт боловсруулах, дотоодын хууль тогтоомжид санал өгөх ажлыг зохион байгуулах.	Судалгаа хийж, санал гаргасан байна.	Г, Х
	1.7. Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хүний эрхэд нөлөөлөх зохицуулалт байгаа эсэхийг тодорхойлон, холбогдох арга хэмжээ авах.	Дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Г, Х

	1.8.Хүний эрхийн чиглэлээр статистик мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийж, тайлагнах.	Статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж, тайлагнасан байна.	Х, Ш
	1.9.Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр зохион байгуулах сургалтын сэдэв, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон, Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлэх.	Сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр		
	1.10.Төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, холбогдох арга хэмжээ авах.	Ажил, арга хэмжээ хамтран хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	1.11.Төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагаас гаргасан хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох ажлыг нэгтгэн зохион байгуулах.	Зохион байгуулалтаар хангасан байна.	Х, Ш
	1.12.Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход үүсэж буй хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх санал, арга хэмжээг тодорхойлж, шийдвэрлүүлэх.	Арга хэмжээг тодорхойлж, шийдвэрлүүлсэн байна.	Г, Х
	1.13.Төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн эрүүгийн болон зөрчлийн хэрэгт нэхэмжлэл гаргах эсэхийг судлуулж, холбогдох арга хэмжээ авах.	Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Х, Ш
	1.14.Иргэн, захиргааны хэргийн хяналтын шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хууль хэрэглээ тогтоосон шийдвэрийн талаар нэгж, прокурорын газарт мэдээлэл, зөвлөмж, албан бичиг хүргүүлж биелэлт, үр дүнг тооцох.	Үр дүнг тооцсон байна.	Г, Х, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Гэмт хэрэг, зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг үнэлж дүгнэх.	Бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлж, ажлын чанар, үр нөлөөг сайжруулах арга хэмжээ авсан байна.	Г, Х
	2.2.Гэмт хэрэг, зөрчил, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус	Хамтран ажиллаж, мэдээлэл солилцсон байна.	Г, Ш

	байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцох, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.		
	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр		
	2.3.Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах.	Төлөөллийг хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	2.4.Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, дэд зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөөнд санал өгөх, тусгагдсан ажлын хэрэгжилтийг зохион байгуулах.	Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Х, Ш
	2.5.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох судалгааг дангаар болон бусад байгууллагатай хамтран хийх ажлыг зохион байгуулах.	Судалгаа хийх ажлыг зохион байгуулсан байна.	Х, Ш
	2.6.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон хэрэгт бичсэн прокурорын дүгнэлтийг нэгтгэн дүгнэж, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлэх.	Дүгнэлт хүргэгдсэн байна.	Х
	2.7.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг нэгтгэн зохион байгуулах.	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Х
	Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр		
	2.8.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дотоодын хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, олон улсын байгууллагын тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах.	Тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авсан байна.	Г, Х
	2.9.Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа хийх ажлыг зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авах.	Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Х
	2.10.Холбогдох зохион байгуулалтын бүтцийн нэгж, нэгж прокурорын газруудаас эрүү шүүлт тулгах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн талаарх мэдээ, мэдээллийг авч, нэгтгэн, дүгнэлт хийх.	Мэдээ, мэдээллийг нэгтгэн, дүгнэлт хийсэн байна.	Х, Ш
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтийг зохион	Бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлж, ажлын чанар, үр нөлөөг сайжруулах арга	Г, Х

	байгуулах, биелэлт, үр дүнг үнэлж дүгнэх.	хэмжээ авсан байна.	
	3.2.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд мөрдөх журмын хэрэгжилтэд хяналт тавих.	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	Х
	3.3.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр нийтэд мэдээлэгдсэн хэрэг, зөрчлийн явц, шийдвэрлэлтийн талаар нийтэд мэдээлэх, ярилцлага өгөх, хэвлэлийн хурал зохион байгуулах.	Олон нийтийн мэдээлэл авах эрх хангагдсан байна.	Х, Ш
	3.4.Прокурорын байгууллага, прокурор, ажилтны тухай хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр гарсан ташаа мэдээлэлд хариу арга хэмжээ авах.	Олон нийтийг мэдээллээр хангасан байна.	Г, Х, Ш
	3.5.Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчээс ирүүлсэн мэдээлэл авах тухай санал, хүсэлтийг танилцуулах, шийдвэрлэх.	Санал, хүсэлтийг танилцуулж, шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш
	3.6.Прокурорын байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	3.7.Олон нийттэй харилцах ажлын үр нөлөөг судалж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох.	Ажил, арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлсэн байна.	Х, Ш
	3.8.Байгууллагын үйл ажиллагаа болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг бэлтгэж, нийтэд түгээх ажлыг зохион байгуулах.	Мэдээ, мэдээллийг нийтэд түгээсэн байна.	Х, Ш
	3.9.Прокурорын байгууллагын цахим хуудсын хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах.	Цахим хуудаст баяжилт, шинэчлэл хийгдсэн байна.	Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	*Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр*		
	4.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.	Төлөвлөлтийг оновчтой хийж, биелэлтийг хангуулсан байна.	Г, Х
	4.2.Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийх мэдээлэл, түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүхтэй харилцах чиглэлээр	Үндэслэл бүхий мэдээлэл, санал, дүгнэлт, тайлбар боловсруулсан байна.	Г, Х

	гаргах санал, дүгнэлт, тайлбарын төслийг боловсруулах.		
	4.3.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журам, зааврын төсөлтэй танилцаж санал өгөх, мөн ирүүлсэн мэдээлэл, албан бичигт тайлбар хийх, зохион байгуулалтын шаардлагатай бусад арга хэмжээг авах.	Үндэслэл бүхий санал, тайлбар боловсруулсан байна.	Г, Х
	4.4.Хариуцсан ажлын чиглэлээр нэгж прокурорын газар, бусад байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг шийдвэрлэх.	Үндэслэлтэй шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш
	4.5.Хариуцсан ажлын чиглэлээр Улсын ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хуралдаанд асуудал хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх.	Шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	4.6.Олон улсын гэрээ, олон улсын байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлангийн хуралд оролцох, Засгийн газраас баталсан Ажлын хэсэгт прокурорын байгууллагыг төлөөлөх.	Прокурорын байгууллагын төлөөллийг хэрэгжүүлсэн байна.	Г
	4.7.Хариуцсан ажлын чиглэлээр нэгж прокурорын газарт зөвлөмж, мэдээлэл, албан бичиг хүргүүлж, үр дүнг тооцох.	Үр дүнг тооцсон байна.	Х, Ш
	4.8.Нэгж прокурорын газарт хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих.	Үндэслэл бүхий үүрэг даалгавар өгч, үр дүнг тооцсон байна.	Х, Ш
	4.9.Дээд шатны прокуророос шилжүүлсэн иргэн, хуулийн этгээдийн өргөдлийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэх.	Хуульд заасан хугацаанд үндэслэлтэй шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш
	Газар, хэлтсийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, гүйцэтгэлд хяналт тавих чиглэлээр		
	4.10.Газар, хэлтсийн прокурор, ажилтны ажил үүргийг хуваарилж, мэргэжлийн удирдлагаар хангах.	Ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцсон байна.	Г, Х
	4.11.Газрын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг тооцох.	Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулсан байна.	Г, Х, Ш
	4.12.Газрын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлүүлж, хяналт тавих.	Бүртгэл хөтлөлтөд хяналт тавьсан байна.	Х

	4.13.Газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, бодлого, зорилтыг уялдуулах.	Ажлын уялдаа холбоог хангасан байна.	Г, Х, Ш
	4.14.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нараас өгсөн үүргийг хэрэгжүүлж, хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр хангах.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, мэдээллээр хангасан байна.	Г
	4.15.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х
	4.16.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эрх зүй (0421)	
Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Дээд шатны прокуророор 3-аас доошгүй жил, эсхүл Улсын ерөнхий прокурорын газарт ахлах прокуророор ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-газрын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны эерэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах;

		-албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Улсын ерөнхий прокурор

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
1. Газрын ахлах прокурор 2. Хэлтсийн дарга, ахлах прокурор 3. Газрын хяналтын прокурор 4. Хэлтсийн хяналтын прокурор 5. Газар, хэлтсийн туслах ажилтан 6. Аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор 7. Аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын хүний эрх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажил хариуцсан прокурор 8. Сум дундын прокурорын газрын хяналтын прокурор Нийт: 8	1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2.Шүүх 3.Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл 4.Хүний эрхийн Үндэсний Комисс 5.Хэвлэл, мэдээллийн байгууллага 6.Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага 7.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага 8.Шийдвэр гүйцэтгэх байгууллага 9.Бусад төрийн байгууллага 10.Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар: А/95

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
ТӨРИЙН ХУУЛЬ ЦАЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН

2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр